



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 308

Улаанбаатар хот

“Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Даатгалын тухай хуулийн 13.1.2, 67.1.3, 69.1.1, 69.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 236 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллаагүй тул “Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл түдгэлзүүлсүгэй.
2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001852